

Академич Б. Ринчений гар бичмэл шүлгүүдийн тухай
(ОХУ-ын Санкт-Петербург хотод хадгалагдаж байгаа гурван дэвтэр)

Г. Галбаяр
(МУИС)

Нэг. Б. Ринчений гар бичмэл шүлгүүдийн тухай

XX зууны Монголын бичгийн их хүн, нэрт соён гэгээрүүлэгч, эрдэмтэн зохиолч Йөншөөбү Бямбын Ринчен авгайн бүтээл туурвилын эхэн үеийг төлөөлөхүйц сурагч дэвтэрт монгол бичгээр хичээнгүйлэн хар түүшээр таталж бичсэн гурван дэвтэр шүлэг, ертөнцийн соёлын "Алтан гадас" болж гялалзах ОХУ-ын Санкт-Петербург хотын Дорно дахины хүрээлэнгийн номын сангийн монгол номын хөмрөгт хадгалагдаж байна.

Нэгдүгээр дэвтэр нь нүүрэн дээрээ **Б. РИНЧЕН "МИНИЙ ШҮЛГҮҮД" НЭГДҮГЭЭР ДЭВТЭР** гэж бичсэн. Инв. 1934 г, н°24. Е 200, Mong Nova 292. Инв 1962 н°1453 гэсэн дансны дугаар шифр хийгээд уг номын санд авсан оныг тэмдэглэсэн байна. Нүүрэн дээрээ навч, навчны дээрээс нар мандаж байгаа зураг зуржээ. Уул дэвтэрт нэртэй, нэргүй **12 шүлэг** бичээд сүүлд нь Ринчен гэж нэрээ бичсэн ажээ.

Хоёрдугаар дэвтэр нь нүүрэн дээрээ **РИНЧЕН "ШҮЛЭГ" ХОЁРДУГААР ДЭВТЭР** гэж бичсэн. Инв. 1939 г, н°25. Е 201, Mong Nova 293. Инв 1962 н°1455 гэсэн дансны дугаар шифр хийгээд уг номын санд авсан оныг тэмдэглэсэн байна. Нүүрэн дээрээ навчны зураг зурсан. Нийт **17 шүлэгтэй**.

Гуравдугаар дэвтэр нь нүүрэн дээрээ **РИНЧЕН "МИНИЙ ШҮЛГҮҮД" ГУРАВДУГААР ДЭВТЭР** гэж бичсэн. Энэ дэвтэрт орсон шүлгүүдийнхээ доогуур хөх, улаан, хөх гэсэн харандаан будгаар зурсан. Инв. 1934 г, н°24. Е 202, Mong Nova 294. Инв 1962 н°1456 гэсэн дансны дугаар шифр хийгээд уг номын санд авсан оныг, дахин шинэчилсэн дугааруудыг тэмдэглэсэн байна. Нийт **19 шүлэгтэй** ажээ. Энэ гурван дэвтэрт нийт **48 шүлэг** байна.

Эдгээр гурван дэвтэр шүлгийн тухай манай судлаачид "Тэр Ленинградд суралцаж ахуй цагтаа залуу насны цалгим сэтгэлийн онгодоор шүлэг холбоо бичиж Ленинградын их сургуулийн дорно дахины салбарын архивт хадгалуулжээ"¹. "ЗХУ-ын Дорно дахины хүрээлэнгийн Ленинградын (одоо Санкт-Петербург) салбарын номын санд, монгол бичгийн их хүн Б. Ринченгийн яруу найргийн гурван нимгэн дэвтэр хадгалагдаж байна. Уг дэвтэрт 40 орчим богино шүлэг байв. Шүлгүүд нь эх нутгаа эргэн санагалзсан, цаг үеийн хатуу бэрхийг харамсан уймарсан, ард түмнийхээ ёс заншлыг хүндэтгэн илэрхийлсэн зэрэг олон өнгө аястай юм. Их эрдэмтэн маань Ленинград хотноо гучаад

¹ С. Лувсанвандан "Зохиолч Б. Ринчен", Билгүүн номч Бямбын Ринчен, УБ, 1990., х-30.

онд сурч байхдаа бичсэн эдгээр шүлгээс уншигч танд цөөн хэдийг толилуулья"² гэх зэргээр өгүүлж, зарим шүлгийг нь хэвлүүлсэн байна. /Хэвлүүлсэн шүлгүүдийн тухай хойно өгүүлсэн болно/

Дээрх судлаачдын тэмдэглэснээс үзвэл уг шүлгүүдээ Б. Ринчен гуай тэр үеийн Ленинград хотод сурч байх үедээ /1925 - 1927/ бичсэн болох нь харагдана.

Билгүүн номч Б. Ринчен авгайн өөрийнх нь хэлдэг байсанчлан үндэсний соёл, ертөнцийн боловсролд нүд нээж байж сэхээтэн хүн ард олныхоо ухааны "есөн сүв"-ийг нээхэд тус болдог жам, заяа тавилангийн эрхээр тэрбээр 1925-1927 оны хооронд Ленинград хотноо "монголч, академич Владимирцов, энэтхэг судлаач, академич Ольденбург, төвдөч, академич Щербатской, дорно дахины түүхч, академич Бартольд, түрэг хэлний профессор, академич Юдахин, авиан зүйн тухайд академич Щерба, хэл түүхийн мэргэжилтэн, академич Марр, монголч, академич Козин, нангиадач, академич Алексеев нарын есөн академичаар гурван жил тусгай лекц хичээл заалган удирдуулж"³ явахдаа бидний ярьж буй гурван дэвтэр шүлгийг бичсэн байж болох ч ингэж үзэхэд зарим талаар эргэлзээтэй олон зүйл байна.

Учир нь Б. Ринчен гуай энэ гурван дэвтэр шүлгүүдийнхээ бичсэн он сар, өдрийг бүгдийг бүрэн бичээгүй, зөвхөн заримынх нь л сар өдрийг тэмдэглэжээ. Харин хоёрдугаар дэвтэрийн эхний хоёр шүлгийн сүүлд 1923.04.11 гэж бичсэн байна. Энэ он бол бидний бодлоор зохиолчийн шүлэг тэрлэж эхэлсэн эхний цаг үе байх. Гэтэл доорхи шүлгүүдэд:

"Аяа шингэх зүгээс боссон
Шинэ үсэг гарахуй нь гарч байна
Шүтсээр ирсэн үсэг маань
Ширвэгдэн хаягдав!"⁴,

"Сонсолтой чимээ гарав
Сонин соёл мандав
Хамаг харц ард
Хамтралд нэгдэв"⁵,

"Худалч лам нар, хуурамч бөө нар
Хуучин ёс халагдав!
Хашил зовол хагацаж

Хамтын байдал мандав"⁶ гэсэн шүлгүүдэд Б. Ринчен гуай Ленинград хотод сурч байх үеэсээ /1925-1927/ хожуу болсон түүхэн үйл явдлуудын тухай бичсэн байна. Иймд уг гурван дэвтэр шүлгүүд нь 1920-иод оны үеэс эхэлж бичигдсэн ч хожмын шүлгүүдээр баяжигдан сүүлд уг номын санд зориуд хүргэгдсэн бололтой байна. Зориуд гэдгийн учрыг ихэд хичээнгүйлэн, цаг зав зориулж, машид нямбай бичсэн байдал харуулна. Уг шүлгүүдийг бичсэн он сарын хувьд бол зохиолчид зориуд "будлиулж" туршлага заан урагшлуулж, хойшлуулдаг элдэв уран арга гаргасан байдгийг бодолцох хэрэгтэй.

Хоёр. Б. Ринчений энэ гурван дэвтэр шүлэг хэвлэгдсэн эсэх тухайд

Бидний өгүүлэн буй гурван дэвтэр 48 шүлгээс цөөн хэдэн шүлэг л хэвлэгдэж олны хүртээл болжээ. Энэ хэвлэгдсэн цөөн шүлгийг ОХУ-ын Санкт-Петербург хотын Дорно дахины хүрээлэнгийн номын сангийн монгол номын хөмрөгт хадгалагдаж байгаа шүлгүүдтэй харьцуулж үзье.

² Б. Ринчен /Д. Өлзийбаярын хэвлэлд бэлдсэн/, "Цог" сэтгүүл УБ. 1992., № 2. х-110.

³ "Шинжлэх ухааны академийн жинхэнэ гишүүн, хэл шинжлэлийн ухааны доктор, профессор Ринчен миний гурван үеийн түүх", Билгүүн номч Бямбын Ринчен. УБ 1990., х-14.

⁴ Б. Ринчен "Миний шүлгүүд" ., Нэгдүгээр дэвтэр 5 дахь шүлэг

⁵ Б. Ринчен "Миний шүлгүүд" ., Нэгдүгээр дэвтэр 6 дахь шүлэг

⁶ Б. Ринчен "Миний шүлгүүд" ., Нэгдүгээр дэвтэр 7 дахь шүлэг

"Б. Ринчен гуай шүлэг зохиолоо эхлээд монгол бичгээр бичээд, ахин крилл үсэгт буулгаад бас оросоор өөрөө орчуулан"⁷ гар бичмэлээр олон газар хадгалуулсан байна. Тухайлбал: Шинжлэх ухааны академийн Хэл зохиолын хүрээлэнгийн номын санд "Үнэн голоос гарсан үгсийн бичиг", "Миний шүлгүүд" гэсэн хоёр дэвтэр гар бичмэл шүлэг байгааг эрдэмтэн судлаач Д. Цэнд "ХХ зууны монгол зохиолчид" цувралын №66 дахь "Бямбын Ринчен" номдоо судлан шинжилсэн бол судлаач Ц. Цэрэн Улсын түүхийн төв архивт хадгалагдаж байгаа зарим шүлгүүдийг нь удиртгал тайлбартайгаар 1988 оны "Цог" сэтгүүлийн №6-д хэвлүүлж олны хүртээл болгожээ. Ц. Цэрэнгийн энэ хэвлүүлсэн шүлгүүдээс нэг ч шүлэг бидний өгүүлэн буй гурван дэвтэрт байхгүй байна. Харин эрдэмтэн Д. Цэндийн бүтээлд хэвлүүлсэн шүлгүүдээс хоёр шүлэг бидний ярьж байгаа гурван дэвтэрт давхардан орсон байна.

Б. Ринчений эл гурван дэвтэр шүлгүүдээс уншигч, судлаачдын анхаарлыг хамгийн ихээр татсан шүлэг бол "Сар" /"Саран чавганц"/ шүлэг нь ажээ. Уг шүлгийг эрдэмтэн Д. Цэнд "Миний шүлгүүд" нэртэй гар бичмэл эхээс нь авч хэвлүүлэхдээ "Сар" гэсэн гарчигтайгаар:

"Цоохор шар саран **чуганц** /нутгийн аягуу бололтой/

Цоорхой үүлэн дээлээ хэдрээд

Туяан цагаан таягаа тулан

Тугал олон сүргээ туув

Үүлэн цоорхой дээлийг нь **ноолоод**

Уяхан хөвгүүн салхи үлээн **наадвай**"⁸ гэсэн байна.

Тэгвэл 1958 онд хэвлэгдсэн Б. Ринчений "Бэр цэцэг" шүлгийн түүвэрт "Сар" нэртэйгээр:

"Цоохор шар саран **чавганц**

Цоохор үүлэн дээлээ хэдрээд

Туяан цагаан таягаа тулан

Тугал олон **одон** сүргээ туув

Үүлэн ноорхой дээлийг нь **ноолон**

Үеэл хөвүүн салхи үлээн **наадав**"⁹ хэмээн тодорхой хэмжээний зөрөөтэйгөөр хэвлэжээ.

Тэгвэл бидний авч үзэж байгаа гурван дэвтэр шүлгийн гуравдугаар дэвтэр "Миний шүлгүүд"-д "Саран чавганц" нэртэйгээр:

"Цоохор шар саран **чавганц**.

Цоохор үүлэн дээлээн хэдрээд

Тугал олон **одон** сүрэгээн тууж

Туяан цагаан таягаан **тулж гарав**

Үүлэн ноорхой дээлийг нь **ноолон татан**

Өнгөлэй хөвгүүн салхи үлээн **наадмой**"¹⁰ гэсэн байна.

Энэ гурван эхийг бусад хэвлэгдсэн эхүүдийн төлөөлөл болгон авч үзэхэд цөөнгүй зөрөө тодорхой харагдаж байна.

"Саран чавганц" шүлгийн дараагаар бидний авч үзэж байгаа 48 шүлгээс "Р-д" шүлэг нь нэлээд олон хэвлэгджээ. Тухайлбал эрдэмтэн судлаач Д. Цэндийн хэвлүүлсэн эхэд "Ра-д" гэсэн гарчигтайгаар:

"Зүүсэн нэр минь ондоо боловч

Зөв утга нь нэгэн бус уу?

⁷ Бямбын Ринчен "Хэвтаснаас олдсон шүлгүүд" ., "Цог" сэтгүүл УБ 1988 . №6 /Хэвлэлд бэлтгэсэн Ц. Цэрэн/

⁸ Д. Цэнд "Бямбын Ринчен" ., "ХХ зууны монгол зохиолчид" цуврал № 66., УБ. 2001., х-17

⁹ Б. Ринчен "Бэр цэцэг" УБ. 1958., х-3

¹⁰ Б. Ринчен "Миний шүлгүүд" ., Гуравдугаар дэвтэр 1 дэхь шүлэг

Төрсөн бие минь ондоо боловч
Төв **сэтгэлгээ** нь нэгэн бус уу ?¹¹
хэмээсэн бол Б. Ринчений мэндэлсний 85 жилийн ойд зориулан гаргасан *"Билгүүн номч Бямбын Ринчен"* бүтээлийн эхний нүүрэнд ямар нэгэн гарчиггүйгээр афоризмын үүрэгтэйгээр:

"Зүүсэн нэр маань ондоо боловч
Зөв утга нь нэгэн бус уу?
Төрсөн бие маань ондоо боловч
Төв **сэтгэл** минь нэгэн бус уу ?"¹² хэмээн хэвлэжээ.

Тэгвэл бидний авч үзэж байгаа гар бичмэлд "P-д" гэсэн гарчигтайгаар:

"Зүүсэн нэр маань ондоо боловч
Зөв утга нь нэгэн бус уу ? ..
Төрсөн бие маань ондоо боловч
Төв **сэтгэл** минь нэгэн бус уу ? ..." ¹³ гэж бичсэн байна.

ОХУ-ын Санкт-Петербург хотын Дорно дахины хүрээлэнгийн номын сангийн монгол номын хөмрөгт хадгалагдаж байгаа шүлгүүдээс хамгийн олныг буюу 9 шүлгийг эрдэмтэн судлаач Д. Өлзийбаяр 1992 оны *"Цог"* сэтгүүлийн №2-т хэвлүүлж уншигчдын хүртээл болгожээ.

Б. Ринчен эл гурван дэвтэр шүлгийг зориуд гэмээр маш их таталж бичсэн тул тайлж уншсан эхүүдэд тодорхой хэмжээний зөрөө гарч байгааг Д. Өлзийбаярын хэвлүүлсэн эх, бидний уншиж хэвлэлд бэлдсэн эх хоёр харуулж байна. Энэ зөрөөг доорх харьцууллаас харж болно.

"Цог" сэтгүүлд хэвлэгдсэн эх

Цас

Хөх өндөр тэнгэрийн хайр хишиг
Хүйтэн амьсгалт цагаан цас унаж
Хөвчин их орон дэлхийг
Хөвөн цагаан хөнжлөөр хучив

Зүсэн нэр маань ондоо боловч
Зөв утга нь нэгэн бус уу ? ...
Төрсөн бие маань ондоо боловч
Төв **сэтгэлгээ** минь нэгэн бус уу ? ...

Хөх сайхан тэнгэрийг минь
Хөөт хар үүл бүрхэв.
Хөвчин сайхан нутгийг минь
Хүдэн манан хүрээлэн татав.
Өндөр хөх тэнгэр юүгээн
Үүлэн үгүйг үзээсэй би !
Өргөн уудам нутаг юугаан
Огтоос (?) сэргээхийг үзээсэй би !

Бидний хэвлэлд бэлтгэсэн эх

Цас

Хөх өндөр тэнгэрийн хайр хишиг
Хүйтэн амьсгалын цагаан цэцэг унаж
Хөвчин их орон дэлхийг
Хөвөн цагаан хөнжлөөр хучив

P-д

Зүүсэн нэр маань ондоо боловч
Зөв утга нь нэгэн бус уу ? ...
Төрсөн бие маань ондоо боловч
Төв **сэтгэл** минь нэгэн бус уу ? ...

Хөх сайхан тэнгэрийг минь
Хүнд хар үүл бүрхэв.
Хөвчин сайхан нутгийг минь
Хүдэн манан хүрээлэн татав.
Өндөр хөх тэнгэр юүгээн
Үүлэн үгүйг үзээсэй би !
Өргөн уудам нутаг юугаан
Өндийн сэргэхийг үзээсэй би !

¹¹ Д. Цэнд *"Бямбын Ринчен"*, "ХХ зууны монгол зохиолчид" цуврал № 66., УБ. 2001., х-18

¹² *"Билгүүн номч Бямбын Ринчен"* УБ. 1990., х-2.

¹³ Б. Ринчен *"Миний шүлгүүд"*, Гуравдугаар дэвтэр 6 дахь шүлэг

Өвөлийн хүйтэн цасан арилаад өнгө
бүрийн цэцэг дэлгэрэн **анхилаад**
Өмнө зүгээс галуу шувуу ганганан
ирэхүй цагт
Алс хол умар орноос чам юугаан
ирэв ээ хэмээн
Ай миний чихэн дор сонсогдвоос
зүрх минь **цохилном, цохилном**

Хуучин нь ул, шинэ нь зул болсон
энэ үеэс дор
Хайрт эрдэнэ юүгээн танил үгүй
алдуузай нөхөд өө !
Саарыг огооровч сайныг сахин
хамгаалах бус уу ?
Санамсаргүй **хийвэл** дахин
хаанаас **эрнэм** билээ

Хүчирхэгүүд **дарангуйлах**
ёс журам мөхөхөд
Хүний балмад **сүгийг**
эгнэгт тэвчин огоорч
Эртний мэргэд уул модны **хөл дор** оршин
Энх **төвшнөөр** өөр сэтгэлээн амгалан
суух бүлгээ
Энэ цагийн өчүүхэн мунхгийн биед
Эртний мэргэдийг дуурайн чадах
хувь хамаа аж
Олон нийтээр согтууран бүхий энэ **үеэд**
Орчлонгийн жам ёсон ийм буюу хэмээн
суухаас өөр яанам !

Үдэш болмогц **лаан** гэрлийг
сүүмэлзүүлэн шатааж би
Өн өнгөрсөн эрт цагийн **цас-үлгэрийн**
далайг үзнэм
Орчин тойрон явах зорчих хүний
чимээ намдаж
Оюун сэтгэл минь орчлонгийн
үймээнээс **ангижрам амой**

Дээрх харьцуулалтаас үзвэл бидний ярьж байгаа зохиолч Б. Ринченгийн ОХУ-ын Санкт-Петрбург хотын Дорно дахины хүрээлэнгийн номын сангийн монгол номын хөмрөгт хадаглагдаж байгаа шүлгүүдийн цөөн хэд нь уншигчдын хүртээл болсон ч бидний уншсан эхтэй тулгаж үзвэл үг-үсгийн төдийгүй утгын ч цөөнгүй зөрөөтэй болох нь харагдав. Иймд Б. Ринчений энэ тэнд хадгалагдан үлдсэн гар бичмэл шүлгүүдийг эх бичиг, сурвалж судлалын үүднээс нарийвчлан судалж үндсэн эхийг тогтоох явдал чухал байна.

Гурав. Б. Ринчений гурван дэвтэр шүлгийн утга, уран сайхны онцлог

Б. Ринчен авгай уран бүтээлээ 1920-иод оноос яруу найргийн төрлөөр эхэлж, "зохиолч, яруу найрагч, кино зохиолч, шүүмжлэгч, сэтгүүлч, орчуулагч, судлаачийн олон талт баялаг өвийг үлдээж,

№3 ирэв хэмээн сонсов

Өвөлийн хүйтэн цасан арилаад өнгө
бүрийн цэцэг дэлгэрэн **анхилан**
Өмнө зүгээс галуу шувуу ганганан
ирэхийн цагт
Алс хол умар орноос чам юугаан
ирэв хэмээн
Аяа миний чихэн дор сонсогдвоос
зүрх минь **цохилном ...**

Хуучин нь ул, шинэ нь зул болсон
энэ үеэст
Хайрт эрдэнэ юүгээн танил үгүй
алдуузай нөхөд өө !
Саарыг огооровч сайныг сахин
хамгаалалтай бус уу ?
Санамсаргүй **гэхлээр** дахин
хаанаас **харнам** билээ

Хүчирхэгүүд **дарангуйлан**
ёс журам мөхөхөд
Хүний балмад **сүрэгийг**
эгнэгт тэвчин огоорч
Эртний мэргэд уул модны **гүнд** оршин
Энх **төвшнөөр** сэтгэлээн амгалан
суух бөлгөө
Энэ цагийн өчүүхэн мунхгийн биед
Эртний мэргэдийг дуурайн чадах
хувь заяа хаа ажээ
Олон нийтээр согтууран бүхий энэ **үеэст**
Орчлонгийн жам ёс ийм буюу хэмээн
суухаас өөр яана !

Үдэш болмогц **лавын** гэрлийг
сүүмэлзүүлэн шатааж би
Өн өнгөрсөн эрт цагийн **үгс-үлгэрийн**
далайг үзмой ...
Орчин тойрон явах зорчих хүний
чимээ намдаж
Оюун сэтгэл минь орчлонгийн
үймээнээс **ангижран салмой**

манай уран зохиолын хөгжлийн хагас зууны түүхийн /1929-1977/ өвөрмөц толь¹⁴ болжээ. Энэ утгаараа монгол утга соёл, хэлбичиг, нийгэм-түүхийн шинжлэх ухааны салбарын судалгаанд "РИНЧЕН СУДЛАЛ" гэсэн томоохон эх хэрэглэгдэхүүн болжээ.

Өдгөө Б. Ринчен авгайн "яруу найргийг нь 1920-1930 оны үе, 1940-1950 оны үе гэж хоёр хуваан"¹⁵ судлахдаа түүний урлах арга барил, уран дүрслэлийн онцлогийг ч багагүй анхаарч байна.

Судлаачдын тэмдэглэснээр яруу найргийн нэгдүгээр үе буюу 1920-1930 -аад оны үедээ тэрбээр шүлэг зохиолоо "ардын аман зохиол, дорно дахины яруу найргийн уламжлал дээр, заримдаа шүлэг үргэлжилсэн үгийг хольж бичих өвөрмөц хэлбэрийг шохоорхох байдлаар туурвиж байсан онцлогтой юм"¹⁶. Мөн энэ шинж чанарыг нь "Б. Ринчен ардын зохиолч билээ. Тэр ардын билиг зүйгээс уран бүтээлийн эх сурвалж хэрэглэгдэхүүнийг олж мэддэг төдийгүй, бас өөрийн ардын хууч ярианы нэгэн гол дүр болжээ"¹⁷ гэсэн судлаачийн дүгнэлт давхар батална.

Б. Ринчен зохиолчийн өдгөө мэдэгдэж буй анхны бүтээл нь "Үнэн голоос гарсан үгсийн бичиг" нэртэй бичмэл дэвтэр бол хамгийн түрүүнд "Шар хувалз нарт" шүлэг нь 1929 оны "Уран үгсийн чуулган"-д хэвлэгджээ.

Тэгвэл бидний ярьж буй гурван дэвтэр шүлэг бол түүний яруу найргийн нэгдүгээр үед голчлон хамаарах тул шүлэг зохиол бичиж эхэлсэн анхны онцлог, шүлгүүдийнх нь дүр дүрслэл, үзэл санаа зэрэг олон талыг авч үзэж болох ч энэ удаад **А/ утга, агуулга Б/ дүрслэл, уран сайхных нь** хувьд цөөн ажиглалт хийж байна.

А/ Утга, агуулгын хувьд зарим ажиглалт

Б. Ринчен ярьж буй гурван дэвтэр 48 шүлэгтээ:

1/ Амьдрал ахуйдаа тохиосон өдөр тутмын үйл амьдралаас сэтгэл татсан зарим зүйлийг уран яруу дүрсэлжээ. Түүний "Цас" шүлгийн:

"Хөх өндөр тэнгэрийн хайр хишиг
Хүйтэн амьсгалын цагаан цэцэг унаж
Хөвчин их орон дэлхийг
Хөвөн цагаан хөнжлөөр хучив"¹⁸ хэмээн том том ширхэгээр шүхэрлэн бууж, байгаль дэлхийн өнгө үзэмжийг гоёж, агаар ахуйг цэвэрлэж байгаа нэгэн эгшний зураглал юм уу, аль эсвэл:

"Гэгээн нарны гэрэл хотол дор түгээмэл гялбалам
Цэнхэр сайхан тэнгэрийн цэлмэг ахуйг үзэгтүн!
Өнгө бүрийн цэцэг анхилан энхилэн
Үе навч дэлгэрсэн шугуй моддыг үзэгтүн!
Аяа алтан дэлхийн тоосыг хөдөлгөн
Амьд явах нь цэнгэлийн манлай бус уу ?

Зүйл бүрийн шувууд жиргэн донгодон
Зүлэг ногоонд бэлчин явах малыг үзэгтүн!
Хонгор сайхан хонь хурга майлан
Хот айлын нүүн явахыг үзэгтүн!
Аяа алтан дэлхийн тоосыг хөдөлгөн
Амьд явах нь цэнгэлийн манлай бус уу ?"¹⁹ ... гэж байгаль дэлхийнхээ сайхныг эзэн хүний хангалуун, бахархлын өнгө аясаар илэрхийлж, нөгөөр талаар:

¹⁴ Д. Цэнд "Бямбын Ринчен", "XX зууны монгол зохиолчид" цуврал № 66., УБ. 2001., х-6

¹⁵ Д. Цэнд "Бямбын Ринчен", "XX зууны монгол зохиолчид" цуврал № 66., УБ. 2001., х-16

¹⁶ Д. Цэнд "Бямбын Ринчен", "XX зууны монгол зохиолчид" цуврал № 66., УБ. 2001., х-16

¹⁷ С. Лувсанвандан "Зохиолч Б. Ринчен", Билгүүн номч Бямбын Ринчен. УБ 1990., х-28

¹⁸ Б. Ринчен "Миний шүлгүүд" ., Гуравдугаар дэвтэр 13 дахь шүлэг

¹⁹ Б. Ринчен "Шүлэг" ., Хоёрдугаар дэвтэр 10 дахь шүлэг

Ая алтан дэлхийн тоосыг хөдөлгөн

Амьд явах нь цэнгэлийн манлай бус уу ? гэсэн уран давталтаар бадаг бүрийн хооронд нь холбож, хүч нэмэгдүүлэн, утгыг салгах, нэгтгэх үүргээр ашиглан шүлэглэснээс түүний авьяас билгийг харж болно.

2/ Эх орноо, уламжлалт язгуур урлаг, соёлоо магтан дуулсан агуулгатай магтаал шүлэг цөөнгүй байна. Үүнд:

“Сүнсний минь гол болсон
Сүлдний минь тэнгэр болсон
Сэтгэлийн минь чимэг болсон
Санааны минь эзэн болсон
Алдар их нэрээн мандуулсан
Алтан Монгол улс минь !”²⁰ зэрэг бүтээлээр төлөөлүүлж болохоор байна.

Тэрбээр монгол ард түмний олон үеийн турш тээж ирсэн оюуны соёлыг судлан шинжилж шинжлэх ухааны судалгааны хүрээнд оруулсан гавьяатан билээ. Энэ нөр их ажлынхаа зэрэгцээ монголчуудын оюуны соёлын гайхамшгийг магтан дуулж, өөрийн уран бүтээлийн нэгэн хэсэг болгосон нь судлуштай зүйлийн нэг билээ.

3/ Цаг үеийнхээ өөрчлөлт, хувиралтай зөрчилдөн өөрийн үзэл бодлыг ирэрхийлсэн шүлэг нэлээд байна. Тухайлбал:

“Ая шингэх зүгээс боссон
Шинэ үсэг гарахуй нь гарч байна
Шүтсээр ирсэн үсэг маань
Ширвэгдэн хаягдав!”²¹ гэж бүхэл түүхийн туршид оюун сэтгэлгээний гүүр болсоор ирсэн үндэснийхээ бичиг соёлыг халж сольсон гашуун үнэнийг дургүйлхэн угтсан шүлгүүдээр төлөөлүүлж болно.

4/ Цаг үеийнхээ зарим овь мэх, залиар түрээ барьсан, этгээд гажуу, хийхээсээ хэлэх нь их нэгнийг:

“Гэдэн гэдэн алхалтай
Гэдэс дүүрэн эрдэмтэй
Хүр хүр дуутай
Хүрээлэнд суудалтай
Гожгор шар дүртэй
Гоонин шар хатантай
Хүрээлэнг тэтгэсэн санаатай
Хүнээс илүү гавьяатай
Тэр хэн бэ ?”²² гэхчлэн хөрөгчлөн дүрсэлжээ. Ардын аман зохиолын уламжлалыг ашиглаж цаг үеийнхээ үйл явдлуудыг хөрөгчлөн дүрсэлж шинэ уран зохиолын бичлэгийн хэлбэрт идээшүүлсэн шүлгүүдээс тодорхой харагдаж байна.

5/ Хойч үедээ зориулж сургасан, тэдэнд амжилт ерөөсөн агуулга бүхий шүлгүүд элбэг юм. Үүнийг “Ерөөл” шүлгийн нь:

“Юүлэн авсан энэ төрөл тань
Ертөнцөд төрсөн энэ бие тань
Хэвтэж өвдөх хишиг томуугүй

²⁰ Б. Ринчен “Шүлэг” ., Хоёрдугаар дэвтэр 11 дэхь шүлэг

²¹ Б. Ринчен “Миний шүлгүүд” ., Нэгдүгээр дэвтэр 5 дахь шүлэг

²² Б. Ринчен “Миний шүлгүүд” ., Нэгдүгээр дэвтэр 8 дахь шүлэг

Хэрэлдэж тэмцэх хэрүүл баруул үгүй
Энэлэн гаслах зовлон зүдгүүр үгүй
Эвдрэлдэн хямралдах атаа жетөө үгүй
Санаа сэтгэл амар, тав хүсэл дүүрэн
Сацлал үгүй сайхнаар жаргатугай!"²³ гэсэн мөрүүд илтгэнэ.

Б. Ринчений энэ гурван дэвтэр шүлгийн нэлээд хэсэг нь ардын аман зохиолын бичлэг, сэтгэлгээнээс эхтэй бөгөөд түүнийгээ орчин цагийн бичлэг сэтгэлгээний онцлогтой холбож чадсан нь сонирхолтой юм. Өөрөөр хэлбэл дээрх шүлэгт монголчуудын аман ерөөлийн хэлбэр сэтгэцээс орчин үедээ чадварлаг идээшүүлсэн нь тодорхой харагдаж байна.

6/ Ертөнцийн зан аалийг эрэгцүүлэн бясалгаж, өөрийн үзэл бодлоо утга далдлан илтгэсэн гүн ухааны аястай шүлгүүд цөөнгүй байна. Тухайлбал: "251 дүгээр хашаа" шүлгийн:

"Хашаан дотор өвс ногоо ургаад
Хаалганы өмнө элс шороо дарав
Аяа ертөнцийн ёсон ийм буюу
Амьтны хөл татарч, агшин дор аглаг болов"²⁴ хэмээсэн утга уянгаас юмуу, аль эсвэл "Нөхрөөсөө хагацав" шүлгийн:

"Учирсан бүгд эцэсдээн хагацах нь
Орчлонд төрсөн бидний үүрдийн жам ёсон бус уу?...
Үйлээн мэдсээр атал осол үгүй энэ үнэнийг
Онц над дор тохиолдсон хэмээж болмой үүнийг..."²⁵ гэсэн шүлгээс, мөн "P – Ө" шүлгийн:

"Зүүсэн нэр маань ондоо боловч
Зөв утга нь нэгэн бус уу? ...
Төрсөң бие маань ондоо боловч
Төв сэтгэл минь нэгэн бус уу?..."²⁶ гэсэн шүлгүүдээр төлөөлүүлэн ойлгож болохоор байна.

Эдгээр шүлгүүдэд гүн ухааны ойлголтоос гадна ертөнцийн жам ёсны хувьсан орчих жамыг яруу сайхан нээжээ. Энэ эрэл хайгуул нь гүнзгийрч хожмын алдарт "Монгол хэл", "Бэр цэцэг" зэрэг гүн ухааны бодомжит шүлэг найргийн нь суурь болжээ.

Б/ Дүрслэл, уран сайхных нь хувьд зарим ажиглалт

1/ Б. Ринчен шүлгүүддээ ардын аман зохиол төдийгүй бөөгийн яруу найргийн уламжлалыг XX зууны монгол яруу найрагт идээшүүлсэн байна. Жишээ нь:

"Ханын хаяа суудалтангууд
Харанхуй шөнө гүйдэлтэнгүүд
Хүний унаанд явдалтангууд
Хүйтэн хөх царайтангууд..."²⁷ гэсэн мөрүүд гэрчлэнэ. Шүлэг холбож, утга урлах энэ өвөрмөц аргыг Д. Нацагдорж "Миний нутаг" хэмээх алдарч шүлгээ бичихдээ чадварлаг ашигласан байдаг нь анхаарал татаж байна. Энэ бол угтаа монгол бөөгийн яруу найргийн бичлэгийн арга маяг уугуул монгол шүлгийн тогтолцооний суурь байсныг харуулахаас гадна 1920-30 -аад оны шинэ залуу уран бүтээлчдийн эрэл хайгуул, нөхөрлөлийг илтгэх ажээ.

²³ Б. Ринчен "Миний шүлгүүд" ., Гуравдугаар дэвтэр 3 дахь шүлэг

²⁴ Б. Ринчен "Шүлэг" ., Хоёрдугаар дэвтэр 4 дэхь шүлэг

²⁵ Б. Ринчен "Миний шүлгүүд" ., Гуравдугаар дэвтэр 5 дахь шүлэг

²⁶ Б. Ринчен "Миний шүлгүүд" ., Гуравдугаар дэвтэр 6 дахь шүлэг

²⁷ Б. Ринчен "Миний шүлгүүд" ., Гуравдугаар дэвтэр 10 дахь шүлэг

2/ Бичгийн хэлэнд суурилсан бие даасан дууны яруу найраг гэж хэлж болохоор шүлэг бичсэн нь ХХ зууны монгол яруу найргийн эхэн үеийн түүхэнд онцлог байна гэж үзэж болно. Учир нь дууны яруу найраг бие даасан төрөл зүйл мөн үү, биш үү гэсэн маргааныг шийдэхэд анхаарах зүйлийн нэг болжээ. Үүнийг:

“Эрээлүүлэнхэн чимэж оёсон
Эрвээхэй л хээтэй алчуурыг
Ээж л минү амарыг ирэн илгээлүгэй
Алчуурыг нь харан харан
Ачит ээж юугаан санамой би ...

Ээж л минь намайг дурдан асуувал аа
Эрдэм ухааны хойноос явсан
Энэ бие минь мэндээрээн дээ ...”²⁸ гэсэн дууны яруу найргийн онцлог болох хөг ая, айзам хэмнэл, аялгуунд утга агуулга нь зангидагдсан онцлогтой шүлгээс харж болно.

3/ Байгалийн дуу авиа, монгол хэлний эгшиг гийгүүлэгчүүдийн дуудагдах хөг эгшигийг ашиглаж дүр бүтээж болдогийг илтгэн:

“Наран нь хэлбийн унаж
Саран нь өндийн гармагц
Зүг бүрээс үүл бөөгнөрч
Бороо нь шаагин шаагин
Салхи нь шуугин шуугин
Юутай сэтгэл уйдам буй !”²⁹ юмуу,:

“Уян зөөлөн сэтгэлтнийг
Уйлуулмаар уран биш л би !
Оюун их ухаантныг
Уяруулмаар сэцэн биш л би !
Холыг харах нүд минь нээгдээгүй л !
Хотолыг мэдэх зөн минь илэрээгүй л !
Сонор сайхан оюун минь дэлгэрээгүй л !
Сод сайхан жигүүр минь өдлөөгүй л !”³⁰ шүлгүүдээс ихийг харж болно.

Монгол хэлний “р, л” гийгүүлэгчийн утгын нууцыг ухаж, зохиолынхоо утгыг илэрхийлж, дүр бүтээж, шүлэг холбож болох онцлогийг ашигласан ажээ. Энэ аргыг 1960-аад онд Б. Явуухулан гаргуун эзэмшсэнийг түүний “Хар ус нуурын шагшуурга”, “Нүүдэлчний намар” зэрэг шүлгүүдээс нь тодруулан харж болох билээ.

Ийнхүү цөөн зүйлийг ашиглаад эцэст нь дүгнэж үзвэл Б. Ринчен авгайн ОХУ-ын Санкт-Петербург хотын Дорно дахины хүрээлэнгийн монгол номын хөмрөгт хадгалагдаж байгаа гурван дэвтэр 48 шүлэг нь утга агуулгын хувьд ихэвчлэн тухайн цаг үеийнхээ нийгмийн зүй бус хөгжлийг шүүмжилсэн аястай бол дүрслэл, хэлбэрийн хувьдаа уугуул монгол хэлний сонгодог найруулга, дэг жаягт суурилж, толгой сүүл, үе өлмий, айзам хэмнэлд зангилагдсан уламжлалт монгол шүлгийн онцлогийг хадгалсан байна.

²⁸ Б. Ринчен “Миний шүлгүүд” .. Нэгдүгээр дэвтэр 12 дахь шүлэг

²⁹ Б. Ринчен “Шүлэг” .. Хоёрдугаар дэвтэр 9 дэхь шүлэг

³⁰ Б. Ринчен “Миний шүлгүүд” .. Гуравдугаар дэвтэр 14 дэхь шүлэг

ДҮГНЭЛТ

1. Б. Ринчен авгайн энд авч үзсэн шүлгүүд нь шинэ цагийн сэтгэлгээгээр баяжигдаж, ардын аман зохиолын уламжлалт бичлэгт суурилсан ерөөл, магтаалын онцлогтой байгаа ч хожмын /1950-иад оны/ гүн ухаан, сэтгэл зүйн эргэцүүлэл нэвтэрхий шингэж, туурвил зүйн ур маяг өв тэгш жигдэрсэн бүтээлүүдийнх нь эхлэл болсныхоо хувьд өвөрмөц ажээ.

2. Ардын аман зохиолын хийгээд уламжлалт бичгийн уран зохиолын өвөрмөц сэтгэлгээ, бичлэгийн арга барилыг өрнөдийн ард түмний уран зохиолын сэтгэлгээ, бичлэгээр баяжуулан боловсруулж чадсанаараа XX зууны монгол уран зохиолын туурвил зүйн хөгжилд чухал хувь нэмэр оруулжээ.

ABSTRACT

1. Although, the poems by Rinchen mentioned here, were enriched with modern thoughts and have some peculiarities including benedictions/wishes/ and odes based on popular folk literature, it is special for being his first work /creature/ of which have philosophy, psychological thoughts and good figures of speech.

2. The great contribution to the mongolian modern literature works is the enrichment of thinking and writing methods of popular folk/oral/ and writing literature with the eastern public ones.